Говь-Алтай аймгийн Анагаахын сургуулийн оюутнуудын Коронавируст халдварын талаарх мэдлэг, дадал, хандлагыг судлах нь

Б.Ундармаа[1], Ж.Сарантуяа[1], Н.Баярмаа[2], Ж.Одонтуяа[1]

[1]АШУҮИС, Говь-Алтай АУС
[2]АШУҮИС
Цахим шуудан: Odontuya.j@mnums.edu.mn , Утас:99489871

Түлхүүр үг:
Дамжих зам
Шинж тэмдэг
Гар угаах
Халдваргүйжүүлэх
Дархлаа

Товч утга:
Үндэслэл: Дэлхий даяар нийт 611.328.308[1] хүн коронавируст халдвараар өвчилсөн ба Монгол улсад нийт 981963 хүн уг халдвараар халдварлагдсан бөгөөд Говь-Алтай аймгийн хүрээнд 19495 хүн халдвар авч, 13397 хүн эдгэрч 19 хүн нас барсан байна.[1] (2022 оны 04 сарын эхний 7 хоногийн байдлаар). Судлаачдын тогтоосноор шинэ короновируст халдвартай нэг өвчтөн дунджаар 3-4 хүнд халдвар тарааж байгаа бөгөөд хүн амын дунд халдварын талаарх мэдлэг, дадал, хандлага хангалтгүй байгаа нь халдварын тархалтад нөлөөлж байгааг судлаачид тогтоож байна.[4] **Зорилго:** АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн оюутнуудын дунд коронавирусийн халдварын талаарх мэдлэг, дадал, хандлагыг судлах **Арга, аргачлал:** Судалгааг аналитик судалгааны агшингийн аргаар АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн оюутнуудын хүрээнд цахим хэлбэрээр google.forms ашиглан 2021 оны 09 сараас 12 сар хүртлэх хугацаанд хийсэн. Судалгаанд нийт 720 оюутан оролцсон. Анагаахын сургуулийн оюутнуудын коронавирусийн халдварын талаарх мэдлэг, хандлага, дадлыг ‘’KAP’’ судалгааны стандарт асуумж ашиглан мэдээлэл цуглуулсан. Судалгааны үр дүнг SPSS 21.0 программ ашиглан тодорхойлсон. **Үр дүн:** Анагаахын сургуулийн оюутнуудын коронавирусийн халдварын талаарх мэдлэг дунджаар 59.7%, хандлага 58.2%, дадал 46.0% байна. Коронавирсийн халдварын талаарх мэдлэг, дадал, хандлага ковидын халдвар авсан болон аваагүй бүлгүүдэд ялгаатай байдал ажиглагдаагүй. P=0.1-0.5, P>0.05. **Дүгнэлт:** 1. Коронавирусийн халдварын талаарх мэдлэг, хандлага хангалтгүй байгаа ч халдвараас сэргийлэх аргын талаарх мэдлэг сайн байсан бөгөөд оюутнуудын ихэнх нь халдварыг аюултай гэж үзэж байна. Халдвараас сэргийлэх өдөр дутамд хэвшүүлэх дадал нь хангалтгүй байгаа нь халдварын талаарх мэдээл, мэдээлэл, сургалт, сурталчилгааг амьдрал хэрэгжүүлж чадахгүй байна. 2. Говь-Алтай аймгийн албан хаагчдын дунд хийсэн коронавирусийн халдварын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгааны үр дүнтэй харьцуулахад анагаахын сургуулийн оюутнуудын коронавируст халдварын талаарх мэдлэг, хандлага, дадлын түвшин доогуур үзүүлэлттэй байна.

Үндэслэл: Дэлхий даяар нийт 611.328.308[1] хүн коронавирус халдвараар өвчилсөн ба Монгол улсад нийт 981963 хүн уг халдвараар халдварлагдсан бөгөөд Говь-Алтай аймгийн хүрээнд 19495 хүн халдвар авч, 13397 хүн эдгэрч 19 хүн нас барсан байна.[1] (2022 оны 04 сарын эхний 7 хоногийн байдлаар).

КОВИД-19 цар тахал нь дэлхийн улс орнуудын эрүүл мэндийн тогтолцоо болон шийдвэр гаргагчдаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бодлого, шийдвэрүүд гаргахыг шаардаж байна. Цар тахал нь хувь хүн болон нийгмийн сэтгэцийн эрүүл мэнд, хэвийн аж амьдрал, харилцаа болон эдийн засгийн

тогтвортой байдалд сөргөөр нөлөөлсөөр байна. Иймээс, энэхүү нөхцөлд бид хувь хүний болон нийгмийн хариу үйлдлийг 1) хүлээж байгаагүй үйл явц болон хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг хэмжих 2) цар тахлын үеийн хариу арга хэмжээ хэрхэн үр дүнтэй, сайн зохион байгуулагдсан байгааг тогтоодог.[2]

Жонс Хопкинсийн их сургуулийн судлаачид COVID-19 халдварын тархалтад нөлөөлж болох таван хүчин зүйлийг нэрлэжээ. Үүнд:

a) Вирусийн хэмжээ: вирусийн тоо бага байгаа үед шинж тэмдэггүй эсвэл хөнгөн хэлбэрийн өвчлөл илэрдэг бол их хэмжээний вирус нь дархлааны системд хүчтэй нөлөөлж улмаар илүү ноцтой хүндрэл үүсгэдэг.
b) Генетик: хувь хүний удамшлын онцлог нь халдварт өртөх эрсдэлд нөлөөлнө. Хүлээн авах эсийн гадаргуугийн бүтэц нь хүн бүрт харилцан адилгүй, өвөрмөц шинж чанартай байдаг. Тухайлбал, зарим хүний эсийн гадаргууд уураг бага байвал Ковид-19-ийн халдварт тэсвэртэй байж болох юм гэжээ.
c) Халдвар дамжих зам: ханиах, найтаах үед агаарт цацагдсан дуслуудаар амьсгалах болон бохирлогдсон гадаргууд хүрэх замаар вирусийн халдвар авах нь өвчний явцад нөлөөлж болно.
d) Вирусийн хоруу чанар: коронавирусийн хоруу чанар ихтэй омог нь эд эсийг гэмтээж, дархлаа сулруулан өвчний явцыг хүндрүүлнэ.
e) Дархлааны байдал: өмнө нь халдварт өвчнөөр өвдсөн эсэх нь коронавируст халдварын үед үзүүлэх бие махбодийн хариу үйлдэлд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр хүчин зүйл нь хүн бүрт ялгаатай тул халдвар авсан хүний өвчний явц, тавилан хэрхэн өрнөхийг таамаглах аргагүй. Тиймээс коронавирус халдвар авсан ихэнх хүн хөнгөн хэлбэрээр өвчилнө гэж үзэж байгаа хэдий ч хэнд ч эрсдэл учирч болзошгүйг цартахлын аюул гэж судлаачид онцолжээ.[3]

Шинэ короновируст халдвартай нэг өвчтөн дунджаар 3-4 хүнд халдвар тарааж байгаа бөгөөд хүн амын дунд халдварын үүсгэгчийн онцлог, дамжих зам, хоруу чанар, дархлааны талаарх мэдлэг, дадал, хандлага хангалтгүй байгаа нь халдварын тархалтад нөлөөлж болохыг судлаачид тогтоож байна.[4]

НЭМҮТ-өөс цахимаар хүн амын мэдлэг, хандлага, дадал тогтоох судалгааг 2020 оны 1 дүгээр сараас эхлэн 3000 гаруй хүнийг оролцуулан авсан ч 80.0 хувь нь дээд боловсролтой, 32.0 хувь нь эрүүл мэндийн салбарын ажилчид байсан.[2]

Коронавируст халдварын тархалтанд нөлөөлж байгаа хүчин зүйлс, халдвар тархах зам, урьдчилан сэргийлэлтийн талаарх сургалт сурталчилгаа нь ихэвчлэн цахим хэлбэрээр хийгдэж байна. Энэхүү сургалт сурталчилгаа нь коронавируст халдварийн тархалтыг бууруулахад хэрхэн нөлөөлж, үр дүн өгч байгааг судлан тогтоох шаардлагатай гэж үзэж байна. Тэр тусмаа хөдөө орон нутгийн анагаахын сургуулийн оюутнуудын коронавируст халдварын талаарх мэдлэг, дадал, ойлголт ямар байгаа, тэдэнд шаардлагатай ямар мэдээллүүд хэрэгтэй байгаа, буруу ойлголтуудыг судлан тогтоох ач холбогдолтой юм.

Зорилго: АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн оюутнуудын дунд коронавирусийн халдварын талаарх мэдлэг, дадал, хандлагыг судлах


Зорилт:

1. Оюутнуудын38 коронавирусийн халдварын талаарх, мэдлэг, дадал, хандлагыг тодорхойлох
2. Говь-Алтай аймгийн албан хаагчдын дунд хийгдсэн коронавирусийн халдварын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгааны үр дүнтэй харьцуулан судлах

Арга, аргачлал: Судалгааг аналитик судалгааны агшингийн аргаар АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны Сургуулийн оюутнуудын хүрээнд цахим хэлбэрээр google.forms платформ ашиглан 2021 оны 09 сараас 12 сар хүртлэх хугацаанд хийсэн. Судалгаанд нийт 720 оюутан оролцсон. Анагаахын сургуулийн оюутнуудын коронавирусийн халдварын талаарх мэдлэг, хандлага, дадлыг ‘’KAP’’ судалгааны стандарт асуумж ашиглан мэдээлэл цуглуулсан. ‘’KAP’’ судалгааны асуумж нь коронавируст халдварын дамжих зам, өвчний үед гарах шинж тэмдэг, халдварт хэн илүү их өртөж болох, урьдчилан сэргийлэлт гэсэн 4 бүлэг 37 асуумжаар мэдлэгийг, коронавируст халдвар аюултай эсэх, халдвар авсан тохиолдолт авах арга хэмжээ, халдвараас сэргийлэхэд тулгарч буй бэрхшээл, хэн нэгэн халдвар авахад таны харьцаанд ямар өөрчлөлт гарах вэ? зэрэг 4 бүлэг 21 асуумжаар халдварын талаарх хандлагыг, гар угаах, амны хаалт хэрэглэх, дархлаа дэмжих, гадуур гарах давтамж зэрэг 4 бүлэг 30 асуумжаар халдвараас сэргийлэх дадлыг үнэлсэн.


Судалгааны үр дүнг SPSS 21.0 программ ашиглан био-статистикийн үндсэн аргуудын тусламжтайгаар арифметик дундаж, дунджийн алдаа, квадрат дундаж хэлбэлзэл, стандарт хэлбэлзэлийг, мөн нас, хүйсийн хувьд ялгаатай байдлыг 95%-ийн итгэх хязгаар (CI)-т тооцож, chi-square тестийг ашиглан харьцуулах бөгөөд тэдгээр хувьсагчуудын дундаж оноог t-test ашиглан харьцуулан тодорхойлсон.

Үр дүн: Судалгаанд нийт 720 оюутан хамрагдсанаас 28.7% нь халдвар авсан, 72.3% нь халдвар аваагүй байв




Зураг 2. Коронавирусийн халдварын талаарх оюутнуудын мэдлэгийг судалсан үр дүн.

Коронавируст халдварын талаарх мэдлэгийг 4 бүлэг 37 асуултаар үнэлсэн. Судалгаанд оролцогчдын 96.5% (95% CI; 93.5-99.5) ханиах, 89.6% (95%CI;80.5-98.5) халдвартай хүнтэй ойр байснаас, 81.3% (95%CI; 76.5-85.5) бохир агаараар дамжин халдварлана гэсэн зөв мэдлэгтэй байгаа боловч бусад халдвар дамжих замын талаарх мэдлэг хангалтгүй байна. Халдварт бага насны хүүхэд, жирэмсэн эх өртөх эрсдэл өндөртэй гэдэг мэдлэг хангалтгүй байна. Халдварын шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдлэг харьцангуй сайн байна.



Зураг 3. Коронавирусийн халдварын талаарх оюутнуудын хандлагыг судалсан үр дүн

Судалгаанд оролцогчдын ихэнх нь коронавирусийн халдвар аюултай гэсэн хандлагатай байгаа боловч халдвараас сэргийлэхэд санхүүгийн бэрхшээл тулгамдаж байна, халдвар илрэхэд гэртээ тусгаарлан эмнэлэгт хандана гэсэн ойлголттой байна. Ихэнх хүмүүс халдвар авсан хүнийг ялгаварлан гадуурхахгүй байх зөв ойлголттой байна.




Зураг 4. Оюутнуудын коронавирусийн халдвараас сэргийлэх дадлыг судалсан үр дүн

Судалгаанд хамрагдсан оюутнууд нь гарыг угааж, халдваргүйжүүлэх дадал нэмэгдсэн хэдий ч зөв дараалалаар угааж халдваргүйжүүлэх дадал хангалтгүй байна. Олон нийтийн дунд орж гадуур гарах давтамжид ихэнх нь өөрчлөлт ороогүй гэж үзсэн байна. Судалгаанд хамрагдсан оюутнуудын ихэнх нь дархлаа дэмжихэд юу ч хэрэглээгүй гэсэн боловч амин дэм, шим тэжээлтэй хоол хэрэглэх, агаарт гарах зэрэг дархлаа дэмжих үйл ажиллагааг хэрэглэж байна.

Хүснэгт 1. Амны хаалтыг хэрэглээний талаарх судалгааны үр дүн

№	Хэзээ зүүдэг эсэх	Албан хаагч. 95% CI	Оюутан 95% CI
1	Гадуур явахдаа	68% (80.0-96.5)	22.6% (10.5-35.0)
2	Нийтийн тээврээр зорчихдоо	60% (95CI 50.0-70.0)	30.7% (20.6-40.5)
3	Худалдаа үйлчилгээний газар орохдоо	89% (95CI 97.0-100)	68.4% (52.5-83.5)
4	Огт хэрэглэхгүй	5% (95CI 1.0-9.5)	6.7% (95CI 80.0-96.5)
5	Дундаж	55.5%	2.1%

Оюутнуудын амны хаалтын хэрэглээ нь албан хаагчдын дунд хийсэн судалгааны үр дүнтэй харьцуулахад доогуур түвшинд байна.



Зураг 5. Коронавирусийн халдварын талаарх оюутнуудын мэдлэг, хандлага, дадлыг албан хаагчдын дунд хийсэн судалгааны үр дүнтэй харьцуулан судалсан үр дүн

Хэлцэмж: ЭМЯ, ДЭМБ. ‘’Коронавируст халдварын талаарх хүн амын мэдлэг, дадал, ойлголтыг тогтоох’’ судалгааны үр дүнд халдварын талаарх мэдлэг 64.2%, гар угаах дадал 41.6% байсан бол бидний судалгаанд мэдлэг 59.7%, гар угаах дадал 47.7% байна.[3]

Hamed Alzoubi1*...COVID-19 - Knowledge, Attitude and Practice among Medical and Non-Medical University Students in Jordan судалгаанд коронавирусийн халдварын шинж тэмдгийн талаарх мэдлэг 90% байсан бол бидний судалгаанд 70% байна.[6]

Б.Отгонням Говь-Алтай аймгийн хүн амын дунд хийгдсэн коронавируст халдварын талаарх албан хаагчдын мэдлэг, дадал, хандлагыг тодорхойлох судалгааны үр дүнтэй харьцуулахад коронавируст халдарын талаарх мэдлэг, хандлагын үзүүлэлт

ойролцоо байсан боловч дадал болгож хэвшүүлэх явдал хангалтгүй байна.[9]

Abiy Tadesse Angelo,1 Knowledge, Attitudes, and Practices Toward Covid-19 and Associated Factors Among University Students in Mizan Tepi University, 2020. Судалгаанд 47%, 54%, and 42.8% нь мэдлэг, хандлага, дадал сайн байсан байгаа нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байна.[12]

Дүгнэлт:

1. Коронавирусийн халдварын талаарх мэдлэг, хандлага хангалтгүй байгаа ч халдвараас сэргийлэх аргын талаарх мэдлэг сайн байсан бөгөөд оюутнуудын ихэнх нь халдварыг аюултай гэж үзэж байна. Халдвараас сэргийлэх өдөр дутамд хэвшүүл дадал нь хангалтгүй байгаа нь халдварын талаарх мэдээл, мэдээлэл, сургалт, сурталчилгааг амьдрал хэрэгжүүлж чадахгүй байна.
2. Говь-Алтай аймгийн албан хаагчдын дунд хийсэн коронавирусийн халдварын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгааны үр дүнтэй харьцуулахад оюутнуудын коронавируст халдварын талаарх мэдлэг, хандлага нь ойролцоо байгаа бол дадал болгож хэвшүүлэх явдал хангалтгүй байна.

Ном зүй:

1. *https://news.google.com. (2022.09.18)*
2. *https://e-mongolia.mn/covid-19/article (2022.09.15)*
3. *Коронавируст халдварын талаар хүн амын мэдлэг, дадал, ойлголтыг судлах судалгаа.УБ.2020. х2,8,15,23*
4. *https://hub.jhu.edu/.../johns-hopkins-covid-temperature-tra.../... (2022-03.12)*
5. *Knowledge, Attitude, and Practice During the COVID-19 Pandemic: A Review. (2022.02.16)*
6. *COVID-19 - Knowledge, Attitude and Practice among Medical and Non-Medical University Students in Jordan. 2022.09.15*
7. *https://journals.plos.org/plosone/article?id=10.1371/journal.pone.0239254. (2022.04.10)*
8. *https://www.sciencedirect.com/science/article/pii/S0195670120301870. (2022.04.15)*
9. *Отгонням.Б. Коронавируст халдварын талаарх мэдлэг, дадал, хандлагыг тодорхойлох судалгаа. 2022.04.15*
10. *https://link.springer.com/article/10.1186/s12889-021-10285-y. (2022.03.20)*
11. *https://journals.plos.org/plosone/article?id=10.1371/journal.pone.0244350https://www.nejm.org/doi/full/10.1056/NEJMoa2001282... (2022.04.12)*
12. *https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC7866950/. (2022.04.15)*
13. *https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=3576906. (2022.0413)*
14. *Knowledge, attitude, and perceptions towards the 2019 Coronavirus Pandemic: A bi-national survey in Africa. PLoS ONE 15(7): e0236918. https://doi.org/10.1371/journal.pone.0236918. (2022.02.23)*

To study the knowledge, practices and attitudes of medical school students about Coronavirus infection in Gobi-Altai province

Undarmaa B[1], Sarantuya J[1], Bayarmaa N[2], Odontuya J[1]

[1]Gobi-Altai Medical school, MNUMS
[2]MNUMS
E-mail: Odontuya.j@mnums.edu.mn, Tel: +976-99489871

Background: A total of 611.328.308 people have been infected with the coronavirus worldwide, a total of 981963 people have been infected with the virus in Mongolia, 19495 people have been infected in Gobi-Altai province, 13.397 people have recovered and 19 people have died. (as of the first 7 days of April 2022).
According to the researchers, one patient infected with the new coronavirus infects 3-4 people on average, and the lack of knowledge, habits, and attitudes about the infection among the population affects the spread of the infection.
Aim: Studying the knowledge, practice, and attitudes about the coronavirus infection among the students of the branch of Medical School in Gobi-Altai, MNUMS
Materials and Methods: The knowledge, attitudes, and practices of medical school students about coronavirus infection were collected using the standard questionnaire of the "KAP" study. A cross-sectional online survey was conducted in from September to December 2021 among medical students in Gobi-Altai, School of Medical Sciences of MNUMS. A total of 720 students participated in the study. Information on sociodemographics and KAP was collected using a web-based questionnaire. Descriptive statistics were used to calculate frequencies and percentages using IBM SPSS 21.
Results: The average knowledge of medical school students about coronavirus infection is 59.7%, attitude is 58.2%, and practice is 46.0%. There were no differences in knowledge, practices, and attitudes about coronavirus infection between the infected and non-infected groups. P=0.1-0.5, P>0.05
Conclusion:

1. First, the knowledge and attitude about the coronavirus infection are insufficient, but the knowledge about the methods to prevent the infection was good, and most students believe that the infection is dangerous. In the absence of infection prevention, routines and practices are not sufficient, so information, training, and advertising about infection cannot be implemented.
2. Compared to the results of the research to determine the knowledge, attitudes, and practices of the employees of Gobi-Altai province about the coronavirus infection, the knowledge, attitudes, and practices of the students about the coronavirus infection are low.

Keywords: Transmission, symptoms, wash hands, disinfection, immunity